



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2014 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 2/170

Арвайхээр

Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоолын 11.2 заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх аймгийн дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга: О.Батжаргал /Аймгийн Засаг даргын орлогч/

Гишүүдэд: Ж.Мягмар /Санхүү төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн/

Д.Рэгзэн /Онги голын сав газрын захиргааны дарга/

Д.Мягмар /Баянтээг ХК-ны захирал/

С.Мягмардорж /АУМ алт ХХК захирал/

Л.Баярсайхан /Бидний түшээ ХХК захирал/

С.Ганцэцэг /ЛЭОСан төрийн бус байгууллагын тэргүүн/

С.Батчимэг /Өвөрхангай өнгө сэтгүүлийн сэтгүүлч/

О.Самбуу-Ёндон /Онги гол хөдөлгөөний дэд тэргүүн/

Нарийн бичгийн дарга: Б.Анхтуяа /Хөгжлийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн /

2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөгөө боловсруулж, дэд зөвлөлийн дүрмийг мөрдлөг болгон оролцох байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлж тогтоолд заагдсан чиг үүргийг ханган биелүүлж, тайлан мэдээг батлагдсан маягтын дагуу хугацаанд нь гаргаж мэдээлж байхыг дэд зөвлөлийн дарга /О.Батжаргал /-д даалгасугай.

3. Зөвлөл байгуулах тухай 2008 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 131 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ТОГТОХСҮРЭН



02 0400

D:My Doc. Zahiramj. Zasag darga